



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/379

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3, 16.4 дэх хэсэг, Оюуны өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлгэдлийг нэгдүгээр хавсралтаар, “Бэлгэдэл, түүнийг хэрэглэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлгэдлийн гарын авлага”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Иргэний нисэхийн ерөнхий газрын гарын авлага”-ыг Оюуны өмчийн газарт бүртгүүлж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Захиргаа удирдлага, хууль, эрх зүйн хэлтэс (З.Туяа), Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Хатанбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба (Б.Мөнх-Очир)-нд даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2015 оны “Бэлгэдэл, түүнийг хэрэглэх журмыг батлах тухай” А/164 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн  
А/379 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт





Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн  
137 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БЭЛГЭДЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлгэдэл, бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэ журмыг мөрдөнө.

1.2. Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлгэдэлд тавигдах шаардлагыг Бэлгэдлийн гарын авлагад тусгаж, баталгаажуулсан байна.

1.3. Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлгэдэл, бэлгэ тэмдэг /лого/, туг нь Иргэний нисэхийн ерөнхий газрын чиг үүргийг хэрэгжүүлэх, олон улсад илэрхийлэх, байгууллагын сүр хүч, эрх хэмжээг илэрхийлнэ. Үүнд:

1.3.1. Бэлгэдэлд зөвхөн цэлмэг тэнгэрийн хөх, алтан шар өнгийг хэрэглэсэн нь Иргэний нисэхийн ерөнхий газар нь төрийн өмнө хүлээсэн үүрэгтээ чин үнэнч, хувиршгүй зүтгэнэ гэсэн санааг бэлгэдсэн болно.

1.3.2. Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний бүрэн эрх. 8.1-т "Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн" гэж заасныг "Алтан соёмбо" илэрхийлнэ.

1.3.3. Иргэний нисэхийн тухай хуулийн 8.2-т "Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагаагаа иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахад чиглүүлнэ" гэж заасныг бэлгэдлийн тэгш байрласан хос алтан далавч, хөх бөмбөрцөг дотор агаарын навигацийн хяналтын дэлгэц, цагаан өнгийн бадам цэцгээр аэродром, нисэх буудлыг илэрхийлж байгаа нь аюулгүй ажиллагаа, нисэхийн аюулгүй байдал, найдвартай, ариун байхыг илэрхийлнэ.

1.3.4. Иргэний нисэхийн тухай хуулийн 8.4.1-т "Чикагогийн конвенцийн Хавсралтуудад нийцсэн аюулгүй ажиллагааны стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, бүртгүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих" гэж заасан. Бэлгэдлийн бөмбөрцгийг ороосон алтан тариан түрүү нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын бэлгэдэлтэй ижил төстэй байгаа бөгөөд иргэний нисэхийн салбарт олон улсын стандартыг нэвтрүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, түүнчлэн эдийн засгийн үр ашигтай иргэний нисэхийн үйлчилгээг илэрхийлнэ.

1.3.5. Бэлгэдлийн доод суурь нь гурвалжин хэлбэртэй ариун цагаан өнгийн бадам цэцгийг дүрсэлсэн нь алсаас харагдаж байгаа агаарын хөлгийн буух, хөөрөх



зурвас, аэродром буюу нисэх буудлын үйлчилгээг төлөөлөх ба нислэг бүр зөөлөн, аюулгүй газардахын бэлгэдэл оршино.

#### Хоёр. Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлгэдэл, бэлгэ тэмдэг /лого/ үйлдэх

2.1. Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлгэдэлд тавигдах шаардлага нь бэлгэдлийн утга санаа, бэлгэ тэмдгийн байгуулалт, ашиглах үсгийн фонт, тексттэй байршуулах хувилбар, хил хязгаар, үсгийн өнгөний код, бэлгэ тэмдгийн хэрэглээ, фото болон зураг дээрх хэрэглээ, зохисгүй хэрэглээг хориглох заалтуудаас бүрдэнэ.

#### Гурав. Бэлгэдлийг хэрэглэх

3.1. Иргэний нисэхийн ерөнхий газрын бэлгэдлийг туг, далбаа, хаяг, албан маягтууд, тушаал, дугтуй, хавтас, ажлын үнэмлэх, гэрчилгээ, ажилтнуудын нэрийн хуудас, ширээний дарцаг, дүрэмт хувцас, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, танилцуулга, ном, сонин, сэтгүүл, CD, DVD, бусад хэвлэл, тээврийн хэрэгсэлд гарын авлагад заасны дагуу хэрэглэнэ.

3.2. Байгууллагын бэлгэдлийг зохион байгуулалтын нэгжүүд нь дотоод албан бичигт хэвлэмэл хуудас хэрэглэх тохиолдолд холбогдох журам болон Бэлгэдлийн гарын авлагад заасны дагуу хэрэглэж болно.

3.3. Байгууллагын бэлгэдлийг бэлэг дурсгалын зүйлс, бусад бараа бүтээгдэхүүнд ашиглаж болох бөгөөд ашиглах тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газраас зөвшөөрөл авна.

#### Дөрөв. Бэлгэдлийг хэрэглэхийг хориглох

4.1. Бэлгэдлийг дараах тохиолдолд хэрэглэхийг хориглоно.

4.1.1. Хувийн зорилгоор ашиглах мэдээлэл, захидал, харилцаа, хэвлэлийн материалд;

4.1.2. Иргэний нисэхийн ерөнхий газрын албан хэрэглээний зориулалтын бус зүйлсэд;

4.1.3. Төрийн бус байгууллага, олон нийтийн үүсгэл, санаачилгын байгууллагууд.

#### Тав. Хариуцлага

5.1. Тус журмын 3.3, 4.1 дэх заалтуудыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oO---



Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн  
А/379 дугаар тушаалын гуравдугаар хэвсрэлт



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
БЭЛГЭДЛИЙН ГАРЫН АВЛАГА

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



BRANDBOOK

Сүхбаатар  
баатар 9/12/2000  
Улаанбаатар  
Улаанбаатар  
Улаанбаатар

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР





### 1. ЛОГО



Логоны бэлгэдэл, утга санаа  
Логоны байгуулалт, үсгийн фонт  
Логог тексттэй байршуулах хувилбар  
Логоны хил хязгаар  
Өнгөний код  
Логоны хэрэглээ  
Фото зураг дээрх логоны хэрэглээ  
Логоны зохисгүй хэрэглээ

### 2. БИЧИГ ХЭРЭГ



Хэвлэмэл хуудас А4, А5  
Дугтуй А4, А5  
Хавтас  
Ажлын үнэмлэх  
Нэрийн хуудас

### 3. БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЛЭЭ



Туг, далбаа  
Ширээний дарцаг  
Хувцас  
CD, DVD  
Танилцуулга  
Бусад хэрэглээ



**И**ргэний нисэхийн тухай хуулийн 8.1-т "Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн" гэж заасныг "Алтан соёмбо" илэрхийлнэ.


Мөн хуулийн 8.2-т "Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагаагаа иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахад чиглүүлнэ" гэж заасан байдаг. Энэхүү бэлгэдэлийн тэгш байрласан хос алтан далавч, хөх бөмбөрцөг дотор агаарын навигацийн хяналтын дэлгэц, цагаан өнгийн бадам цэцгээр аэродром, нисэх буудлыг илэрхийлж байгаа нь аюулгүй ажиллагаа, нислэгийн аюулгүй байдал, найдвартай, ариун байхыг бэлгэднэ.

Хуулийн 8.4.1-т "Чикагогийн конвенцийн Хэвсралтуудад нийцсэн аюулгүй ажиллагааны стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, бүртгүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих" заасан байдаг. Тэгвэл бэлгэдэлийн бөмбөрцгийг ороосон алтан тариан түрүү нь ИКАО-ийн бэлгэдэлтэй ижил төстэй байгаа бөгөөд Олон улсын иргэний нисэхийн төрөлжсөн байгууллагын стандартыг Монгол Улсын иргэний нисэхийн салбарт нэвтрүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, эдийн засгийн үр ашигтай иргэний нисэхийн үйлчилгээг бэлгэдсэн.

Агентлагийн бэлгэдлийн доод суурь нь гурвалжин хэлбэртэй ариун цагаан өнгийн бадам цэцгийг дүрсэлсэн нь алсаас харагдаж байгаа агаарын хөлгийн буух зурвас, аэродром буюу нисэх буудлын үйлчилгээг төлөөлж байгаа бөгөөд, нислэг бүр зөөлөн, аюулгүй газардахын бэлгэдэл оршино. Бэлгэдэл нь алтан шар өнгө, цэлмэг тэнгэрийн хөх өнгөтэй байгаа нь иргэний нисэхийн салбар нь мөнх цэлмэг тэнгэртээ алт мэт үргэлж гялалзаж, өөдлөн хөгжиж байхыг бэлгэдсэн.



## ЛОГОНЫ БАЙГУУЛАЛТ, ҮСГИЙН ФОНТ



Нэрийн текстийн үсгийн фонтод **Arial, Times New Roman** төрлийн фонтуудыг зөвхөн **Regular, Bold** хэлбэрээр ашиглана.



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР

IMPLEMENTING AGENCY OF THE GOVERNMENT

**CIVIL AVIATION  
AUTHORITY**

Сурталчилгаа мэдээллийн материалд орох бичвэрүүдэд **Open Sans, Roboto Condensed** фонтуудыг ашиглана

Open Sans

Roboto Condensed

**АБВГД 1234567890**

АБВГД 1234567890

АБВГД 1234567890

**АБВГДЕЁЖЗИЙКЛМНОӨ 1234567890**

БВГДЕЁЖЗИЙКЛМНОӨ 1234567890

АБВГДЕЁЖЗИЙКЛМНОӨ 1234567890

## ЛОГОГ ТЕКСТТЭЙ БАЙРШУУЛАХ ХУВИЛБАР



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР

25%



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



25%

ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



IMPLEMENTING AGENCY OF THE GOVERNMENT  
CIVIL AVIATION AUTHORITY

- Логоны доод талд ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР нэрийн текстийг 2 мөрт оруулж бичих тохиолдолд логоны далавчны үзүүрийн хязгааруудаас гадагш хэтрүүлж бичихгүй
- Логоны баруун талд мөн 2 мөрөөр байрлуулах бол логоны далавчны дээд хэсгээс доор байрлах бадам цэцгэн суудлын хооронд багтааж бичнэ
- Текст болон логоны хоорондын зай нь 25% утгыг агуулна



## ЛОГОНЫ ХИЛ ХЯЗГААР



Логоны хил хязгаар гэдэг нь логог тойрон хүрээлж буй сул орон зай юм. Хил хязгаар луу бусад дизайны элемент болон текст зэргийг оруулахгүй

## ЛОГОНЫ ӨНГӨНИЙ КОД



Үндсэн өнгө

CMYK - 69-14-0-0

RGB - 0-175-240

WEB - 0099ff

CMYK - 0-19-92-0

RGB - 255-204-42

WEB - ffcc33

CMYK - 75-70-70-90

RGB - 0-0-0

WEB - 000000

CMYK - 0-0-0-0

RGB - 255-255-255

WEB - ffffff

**CIVIL AVIATION AUTHORITY**

**CIVIL AVIATION AUTHORITY**

Туслах өнгө /суурь өнгө ба текстийн/

CMYK - 100-90-10-0

RGB - 37-64-143

WEB - 25408f



## ӨНГӨТ БОЛОН ХАР ЦАГААН ДЭВСГЭР ДЭЭРХ ЛОГОНЫ ХЭРЭГЛЭЭ

Логоны дэвсгэр өнгө



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР

Байгууллагын нэрийг бараан өнгийн дэвсгэр дээр цагаанаар, цайвар өнгийн дэвсгэр дээр кодын дагуух хөх өнгөөр бичнэ



Байгууллагын логог бараан өнгийн дэвсгэр дээр цагаанаар, цайвар өнгийн дэвсгэр дээр хараар байрлуулна



## ЗУРАГТ ХУУДАС ДЭЭР ЛОГОГ ХЭРЭГЛЭХ

Лого нь байгууллагын нэрийн тексттэй хамтдаа байршаагүй байх үедээч байгууллагыг бүрэн илэрхийлэх чадамжтай тул лого оролцож буй аливаа бүтээгдэхүүний дизайнд тохируулах шаардлагаар нэрийн текстээс салангид болон дангаар нь байрлуулахыг зөвшөөрнө.



Бараан өнгийн дэвсгэр зураг дээр цагаан үсгээр бичсэн нэр, логог, цайвар дэвсгэр дээр хар үсгээр бичсэн нэр, логог ашиглана.



Бараан өнгийн дэвсгэр зураг дээр цагаан үсгээр бичсэн нэр, логог, цайвар дэвсгэр дээр хар үсгээр бичсэн нэр, логог ашиглана.





## ЛОГОНД ХОРИГЛОХ ЗҮЙЛС



Өнгө солих



Зааснаас өөр суурь өнгө



Сүүдэр болон строк хийх



Логоны харьцааг эвдэх



Өөр фонтууд ашиглах



Уусгалт цайралт хийх




Цоолбор зураг оруулах



Логог ташуу байрлуулах




Нэр муруйлгаж тахийлгах





## АЛБАН БЛАНК А4




Хэвлэмэл хуудасны шрифтийн фонт нь зөвхөн **Arial**,  
**Times New Roman** байх бөгөөд **Regular**, **Bold** хэлбэрийг ашиглана

Шрифтийн хэмжээний хязгаар нь +13pt, -8pt байна  
Шрифтийн өнгөний код нь **CMYK 69-14-0-0** эсвэл **100-90-10-0**  
байх ба **Brandbook**-ийн Лого хэсэгт заагдсаны дагуу 100% хар  
цагаан өнгөөр лого болон текстийг хийж болно


Монгол Улсын Архивын ерөнхий газраас тогтоож өгсөн дээрх  
хэмжээсийг чанд мөрдөж албан хэрэгцээнд хэрэглэнэ

АЛБАН БЛАНК А5






# ДУГТУЙ А4



# ДУГТУЙ А5

"А" тал




"Б" тал

Нугалах хэсэг

Наах хэсэг



Гадна тал



Дотор тал





## АЖЛЫН ҮНЭМЛЭХ





## НЭРИЙН ХУУДАС



Агентлагийн хэрэгцээнд соёмбо логотой нэрийн хуудас байж болох бөгөөд зөвхөн фольга ашигласан алтадмал өнгөтэй байна.

Алтан фольганаас өөр өнгө оруулахыг хориглоно.





## БАЙГУУЛЛАГЫН ТУГ

Тугны дэвсгэр өнгө нь цэнхэр байх бөгөөд энэ нь мөнх тэнгэрийн бэлгэдэл юм. Туг нь 100х180 см хэмжээтэй байх бөгөөд логог 110 см зайд багтаан төв хэсэгт байрлуулна. Тугны дээд, доод, баруун талын хүрээнд логоны өнгөний кодын дагуу ижил өнгөөр цацаг чимэглэл хийж болно.



## ШИРЭЭНИЙ ДАРЦАГ



Ширээний дарцагны иш болон далбааг олон улсын стандарт хэмжээнд нийцүүлэх ба бусад улс орны далбаа, байгууллагын логог байршуулахдаа тухайн тэмдэгтийн хэлбэрээс хамаарч хүний харааны баримжаанд тохируулан хэмжээг 1-2см-ын хооронд өөрчилж болно. Дарцагны далбааны өндөр нь ишнийхээ уртын 50 хувиас дээш уртгүй байна.



## ДҮРЭМТ ХУВЦАС

Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч нарын дүрэмт хувцас, хэрэглэл



Энгэрийн болон  
ханцуйн тэмдэг



Савхин хүрэм

Поло цамц, саравчтай малгай

Цув

## ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС

Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч нарын дүрэмт хувцас, хэрэглэл



Өвлийн хувцас



Зуны хувцас



Эмэгтэй өвөл, зуны хувцас








## ХААЛГАНЫ ХАЯГ

Хаягийг 250-300 граммын одтой цаасан дээр хийх ба төвгөр гадаргуутай төмөр сууринд ховилд нь тогтоож тааруулна. Байгууллагын логог заасан хэмжээнд байрлуулах ба уйгаржин, кирилл бичгүүдийг текстийн их багаас хамаарч зайг нь тохируулан хийнэ.





Ихэвчлэн 3 талт брошурын нүүрний загварт ашиглагдана.



**ЭРХЭМ ЗОРИЛГО**

-  ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЗОХИЦУУЛАЛТ СТАНДАРТЫГ САЙЖРУУЛАХ
-  АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ БАТААГАХ
- АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ УЛАМЖЛАЛЫГ ӨӨРЧЛӨХ
-  ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ

**АЛСЫН ХАРАА**

-  АЮУЛГҮЙ, ҮР АШИГТАЙ ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ**  
**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

**НЭР ГАРЧИГ**

[WWW.MCAA.GOV.MN](http://WWW.MCAA.GOV.MN)

БУСАД ХЭРЭГЛЭЭ





БУСАД ХЭРЭГЛЭЭ



БУСАД ХЭРЭГЛЭЭ







2022.03.10

Бүтээсэн: У.Булгантайшир

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
Утас: 71-282061  
И-мэйл: bulgantaishir.u@mcaa.gov.mn

CIVIL AVIATION AUTHORITY OF MONGOLIA  
Tel: (976)71-282061  
E-mail: bulgantaishir.u@mcaa.gov.mn